

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, АВЛИГА,
АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
ЗЭСЭНСҮРЭНГИЙН НАЦАГНЯМЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН
(Эхний хагас жилийн байдлаар)

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх, цахим технологид суурилсан эрх зүйн сургалт, сурталчилгаа зохион байгуулна”							
1.	Арга хэмжээ:1.1. Иргэдийн эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэх бодлого, зохицуулалтыг оновчтой арга хэлбэрээр зохион байгуулна.	Эрх зүйн мэдээлэл, сургалтад хамрагдсан иргэдийн хувь	80%	60%	Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, эрх зүйн сургалт, сурталчилгааны хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр аймгийн Хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны нэгдсэн төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2025 оны А/69 дугаар захирамжаар батлуулан, сум, байгууллагуудад хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин, улирал тутамд тайланг авч ажиллаж байна. Иргэдэд хууль, эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх эрх зүйн хөтчүүдийг жил бүр тодорхой салбар эрх зүйн чиглэлээрх эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж хэвшээд байгаа бөгөөд 2025 оны сургалтыг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтран зохион байгуулахаар төлөвлөөд байна. Мөн дээрх нэгдсэн төлөвлөгөөнд иргэдийн эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэх өдөрлөгийг зохион байгуулахаар төлөвсний дагуу Хүний эрхийн боловсролыг түгээх өдөрлөгийг Хархорин, Гучин-Ус, Богд, Баруунбаян-Улаан суманд, Хуульчийн Пробоно өдөрлөгийг 3 суманд буюу Арвайхээр, Хархорин, Богд	2025.01.02 2024.06.06	90.0

					суманд тус тус холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажиллав.		
	Дэд арга хэмжээ 1.1.1: Эрх зүйн сургалт, сурталчилгааны үр дүнг бодитой дүгнэх аргачлалыг боловсруулан, батлуулна.	Аргачлалыг хэрэгжүүлж ажилласан байгууллагын хувь	-	30%	Эрх зүйн сургалт, сурталчилгааны үр дүнг бодитой дүгнэх аргачлалыг аймгийн Засаг даргын захирамжаар батлуулахаар төслийг боловсруулж эхлээд байгаа бөгөөд, бусад аймаг, яам, агетлагын ажлын үр дүнг үнэлж, дүгнэх актуудаас туршлага судалж, 2025 оны 2 дугаар хагас жилд боловсруулан, батлуулахаар төлөвлөж байна.	2025.02.20 2025.06.04	30.0
	Дэд арга хэмжээ 1.1.2: 2025 оны Эрх зүйн сургалт, сурталчилгааны аймгийн нэгдсэн төлөвлөгөөг гарган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90%	60%	Аймгийн хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын 2025 оны нэгдсэн төлөвлөгөөний төсөлд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудаас санал авч, нэгтгэн боловсруулан аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/69 дүгээр захирамжаар батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах хүрээнд захирамжийн хувийг нэгжийн даргын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 3-2/106 дугаар албан бичгээр сум, байгууллагуудад хүргүүлж, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Тайлант хугацаанд давхардсан тоогоор нийт 30000 мянга гаруй иргэнд хууль, эрх зүйн сургалт, мэдээллийг өгсөн байна.	2025.01.15 2025.06.05	90.0
	Дэд арга хэмжээ 1.1.3: Төрийн байгууллагуудын сургалт, мэдээлэл хариуцсан алба хаагчдад сургалт зохион байгуулах, үйл ажиллагаанд зөвлөн туслана.	Сургалтад хамрагдсан алба хаагчдын тоо	50	55	Төрийн байгууллагуудын сургалт, мэдээлэл хариуцсан алба хаагчдад сургалт зохион байгуулахаар аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн төлөвлөгөөнд тусгуулан, батлуулсан. Сургалтыг 2025 оны 04 дүгээр сард зохион байгуулахаар сургалтын удирдамж, хөтөлбөрийг гарган аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд хүргүүлсэн боловч, тодорхой шалтгааны улмаас хойшлогдож, 2025 оны 2 дугаар хагас жилд зохион байгуулахаар төлөвлөгдөөд байна.	2025.01.15 2025.06.05	30.0
	Дэд арга хэмжээ 1.1.4: Шинээр батлагдсан хуулиуд болон боловсруулж буй хуулийн төсөл, бусад нийтээр дагаж мөрдөгдөх эрх зүйн актын талаарх	Хамтран зохион байгуулсан өдөрлөг, арга хэмжээний тоо	2	3	Аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/69 дүгээр захирамжаар батлагдсан аймгийн хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын 2025 оны нэгдсэн төлөвлөгөөний 1 чиглэл нь шинээр болон шинэчлэн батлагдсан хууль тогтоомжийг сурталчлах зорилтыг тусган батлуулсан. Шинээр батлагдсан хууль	2025.01.06 2025.06.04	90.0

	сургалт, хэлэлцүүлэг, сурталчилгааг төрийн үйлчилгээний мэдээллийн хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор 3-4 суманд “Нээлттэй өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулна.				тогтоомжийн сургалт сурталчилгааг сурталчлах ажлыг сумдын Хууль, эрх зүйн мэргэжилтнүүд болон Засаг дарга нар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний холбогдох агентлагийн дарга нарт чиглэл өгч, сургалт, сурталчилгааг холбогдох байгууллагуудаас зохион байгуулав. Тайлант хугацаанд шинээр батлагдсан Органик хүнсний тухай хуулийг цахимаар иргэдэд олон нийтэд сурталчлах хүрээнд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран контент бэлтгэн олон нийтэд хүргэсэн бөгөөд Гамшгаас хамгаалах тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл зэрэг бусад d.parliament.mn/ сайтад байршуулсан хууль тогтоомжийн төслүүдэд санал авах ажиллагааг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгууллаа.		
	Дэд арга хэмжээ 1.1.5: Хэвлэл мэдээллийн байгууллага болон цахим технологийг ашиглан иргэдэд эрх зүйн сургалт мэдээллийг хүргэж ажиллана.	Зохион байгуулсан сургалтын тоо	5	10	Иргэдэд цахимаар хууль зүйн зөвлөгөө, мэдээллийг түлхүү өгөх чиглэлээр сум, байгууллагуудад чиглэл өгч байгаа бөгөөд тайлант хугацаанд Авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 контент, шинээр батлагдсан хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр болон хууль сурталчлах өдөрлөгийг иргэдэд хүргэх хүрээнд орон нутгийн UNN хэвлэлийн байгууллагатай хамтран ажиллав.	2025.01.06 2025.06.05	70.0
Зорилт 2. Аймгийн Засаг даргаас Хууль зүй, дотоод хэргийн сайд, Монгол Улсын Шадар сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэн, үр нөлөөний шинжилгээ хийж ажиллана.							
2.	Арга хэмжээ 2.1. Аймгийн Засаг даргаас Монгол Улсын Шадар сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдтай 2025 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг зохион байгуулахад хамтран ажиллана.	Хэрэгжилтийн хувь	90,6% 95,8	70%	Монгол Улсын Шадар сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдаас аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангуулах хүрээнд хэлтсийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 3-2/32 дугаар албан бичгээр гэрээнүүдийн хувийг, хэрэгжүүлж ажиллах чиглэлийн хамт хүргүүлж, аймгийн Засаг даргаас шийдвэрлэх зарим үйл ажиллагааг хамтран зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа.	2025.01.06 2025.06.04	90.0

Дэд арга хэмжээ 2.1.1: Хууль зүй, дотоод хэргийн сайдаас аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг боловсруулан батлуулна.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	10%	Аймгийн Засаг даргаас Хууль зүй, дотоод хэргийн сайдтай 2025 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээг хэрэгжүүлж ажиллах чиглэлийг хуулийн байгууллагуудад өгч, гэрээнд тусгагдсан 5 зорилт тус бүрийн хүрээнд холбогдох байгууллага бүрд төлөвлөгөөг гаргуулан, биелэлтэд хяналт тавин, холбогдох арга хэмжээг хамтран зохион байгуулан, аймгийн Засаг даргаас үүрэг хүлээсэн шийдвэрлэх арга хэмжээг шийдвэрлүүлэн ажиллав.	2025.01.05 2025.06.04	70.0
Дэд арга хэмжээ 2.1.2:Шадар сайдаас аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг боловсруулан батлуулна.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	25%	Аймгийн Засаг даргаас Монгол улсын Шадар сайдтай 2025 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээг хэрэгжүүлж ажиллах чиглэлийг орон нутаг дахь Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад өгч, гэрээнд тусгагдсан 4 чиглэлийн хүрээнд арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг холбогдох байгууллага бүрд гаргуулан, биелэлтэд хяналт тавин, холбогдох арга хэмжээг хамтран зохион байгуулж, мөн аймгийн Засаг даргаас үүрэг хүлээсэн шийдвэрлэх арга хэмжээг шийдвэрлүүлэн ажиллав.	2025.02.15 2025.06.04	25.0
Дэд арга хэмжээ 2.1.3:Хууль зүй, дотоод хэргийн сайдаас аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах, үр нөлөөний шинжилгээ хийнэ.	Гэрээний хэрэгжилтийн хувь	2024 оны гэрээний хэрэгжилт 90.6 хувьтай үнэлэгдсэн	25%	Хууль зүй, дотоод хэргийн сайдаас аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, үр нөлөөний шинжилгээг 5 дугаар сард хийхэд 5 зорилтын хүрээндэх нийт 32 арга хэмжээнээс зохион байгуулалтын арга хэмжээнүүд хагас жилийн байдлаар 70 хувийн хэрэгжилттэй байна.	2025.01.06 2025.06.04	25.0
Дэд арга хэмжээ 2.1.4: Шадар сайдаас аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах, үр нөлөөний шинжилгээ хийнэ.	Гэрээний хэрэгжилтийн хувь	2024 оны гэрээний хэрэгжилт 95.8 хувьтай үнэлэгдсэн	25%	Монгол Улсын Шадар сайдаас аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, үр нөлөөний шинжилгээг 5 дугаар сард хийхэд 4 зорилт, нийт 28 арга хэмжээнээс зохион байгуулалтын арга хэмжээнүүд 2025 оны эхний хагас жилийн байдлаар 50 хувийг биелэлттэй бөгөөд мөн төсөвт өртөгтэй арга хэмжээний биелэлт санхүүгийн эх үүсвэргүйн улмаас хангалтгүй байсан. Гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд орон нутаг дахь Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад чиглэл өгч, зарим үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна. Гэрээнд тусгагдсаны дагуу биелэлтийг 2025 оны 12 дугаар сард Шадар сайдын ажлын албанд хүргүүлнэ.	2025.01.06 2025.06.05	25%

Зорилт 3. Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, нотариатчийн үүрэг гүйцэтгэгчийг арга зүйгээр хангаж ажиллана.							
3	Арга хэмжээ 3.1. Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	4	3	Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймгийн Цагдаагийн газар болон холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Хариуцсан чиг үүргийн хүрээнд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2 дэд зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна. Зам тээврийн осол, хэрэг, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн боловсруулан, холбогдох байгууллагуудад хэлтсийн даргын 2025 оны 3-2/301 дүгээр албан бичгээр хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архидан согтуурахтай тэмцэх дэд зөвлөлийн гишүүний хувьд холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа. Тухайлбал: Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр албадан эмчилгээний төвийг аймагт нээн ажиллуулах зардал, байрыг шийдвэрлэх хүсэлтийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн, шийдвэрлүүлж, аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяанд үйл ажиллагаагаа явуулахад бэлэн болоод байна. Төрийн албан хаагчдаас үйлдсэн зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах тухай” 19, 20 дугаар Прокурорын мэдэгдлийн хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомжийн сургалтыг зохион байгуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулан ажиллах чиглэлийг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын Засаг дарга нарт аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 3-2/242 дугаар албан бичгээр чиглэл хүргүүлж, аймгийн Прокуроын газарт мэдэгдлийн хариуг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 3-2/296 дугаар албан бичгээр хүргүүлж ажиллав. Төрийн албаны зөвлөлөөс 01 сарын 06-ны өдөр төрийн албан хаагчдад зохион байгуулсан төрийн	2025.01.06 2025.06.04	100.0

				албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн сургалтыг зохион байгуулахад хамтран ажилласан. Мөн 01 сарын 07-ны өдөр хуулийн байгууллагуудын “Ёс зүйн дэд хороод”-ын үйл ажиллагаатай төрийн албаны зөвлөлийн ажлын хэсэг танилцан, мэргэжил арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Мөн аймгийн хэмжээнд 2025 оны эхний 2 сарын байдлаар ихээр үйлдэгдсэн зөрчил болох Олон нийтийн газар, гудамж талбайд бие зассан, хог хаясан, согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосон газарт хэрэглэсэн зөрчил улсын хэмжээнд тус аймагт хамгийн ихээр бүртгэгдсэнтэй холбогдуулан, зөрчлөөс урьдчилсан сэргийлэх шторкыг хэвлэлийн баг болон аймгийн Хөгжимт драмын Театртай хамтран бэлтгэж, олон нийтэд цахимаар түгээсэн. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээрх ажлын хүрээнд хуулийн байгууллагуудын алба хаагчдыг гэр бүлийн хамтаар оролцуулсан Хамтдаа жаргалтай өдөрлөгийг 05 дугаар сарын 13-ны өдөр аймгийн Гэр бүл, хүний хөгжлийн төв холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажиллав.		
Дэд арга хэмжээ 3.1.1: Сумдын гэмт хэрэг, зөрчлийн криминологийн судалгааг шинэчлэн хийж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг судалгаанд тулгуурлан, үр дүндтэй зохион байгуулна.	Кримнологи судалгаа хийгдсэн сумдын тоо	2017 онд 19 суманд	25%	Гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан, нөхцөлийн судалгааг сум тус бүрээр холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран шинэчлэн хийж, урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулах аймгийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын 02 сарын 03-ны өдрийн А/64 дүгээр захирамжаар байгуулан, гүйцэтгэгчийн сонгон шалгаруулахтай холбоотой ажлын хэсгийн уулзалтыг 4 дүгээр сард зохион байгуулан, Тендерийн сонгон шалгууруулалттай холбоотой ажлын удирдамжийг боловсруулаад байна. Судалгааны зардалд урьдчилсан байдлаар 20.0 сая төгрөг зарцуулагдахаар тооцоо, судалгаа гарсан байгаа бөгөөд 10.0 сая төгрөгийн зардлыг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс шийдвэрлүүлэхээр аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын 2025 оны нэгдсэн төлөвлөгөөнд тусгуулж ажиллав.	2025.01.06 2025.06.04	100.0
Дэд арга хэмжээ 3.1.2: Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	2023 онд Камержуулалт 4 аян зохион байгуулагдсан	25%	Иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, камержуулах ажлыг нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх, “Теле камерын хяналтын дэд төв” байгуулах, түүний аюулгүй байдал, холбогдох зардал, дэд бүтцийн талаар зохицуулсан	2025.01.06 2025.06.04	100.0

	ажлыг зохион байгуулж, хяналтын камерын системийг хөгжүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.				“Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2024 оны 86 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Цагдаагийн газартай хамтран аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор 2025 онд нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн орчинг камержуулах, “Дэд төв”-д мэдээлэл, холбооны сүлжээний үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын дэд бүтцийг ашиглан холбох, засвар үйлчилгээний зардлын тооцоололд үндэслэн нийт 753,4 сая төгрөгийг батлуулсан. Мөн Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн “Теле камерын хяналтын дэд төв”-д улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар суурилуулсан теле камер, аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр гадна орчиндоо суурилуулсан теле камеруудыг холбох, зардалд 30.000.000 /гучин сая төгрөг/-ийг шийдвэрлүүлэх хүсэлтийг Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлээд байна.		
	Дэд арга хэмжээ 3.1.3: Архидан согтуурахтай тэмцэх сайн дурын АА бүлгэмүүд, өөртөө туслах бүлгийн үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллана.	Хамтран ажилласан дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо	2021 онд зөвлөгөөн зохион байгуулж, санамж бичиг байгуулсан	80%	Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй өөртөө туслах бүлгийн үйл ажиллагааг дэмжих хүрээнд аймгийн Засаг даргаас 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний зардлыг шийдвэрлэх хүрээнд тухай бүрт дэмжлэг үзүүлж хамтран ажиллаж байна. Архины хамааралтай иргэдэд зөвлөн туслах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Ариусахуйн үндэс төрийн бус байгууллагын “Өөртөө туслах бүлэг”-т үйл ажиллагаагаа хэвийн явуулахад дэмжлэг үзүүлэх хүрээнд аймгийн Засаг даргын 2025 “Хөрөнгө зарцуулах тухай” А/15, “Дэмжлэг үзүүлэх тухай” А/319 дүгээр захирамжийг гаргуулан ажиллав. Мөн бүлгийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, олон нийтэд үйл ажиллагааг нь таниулах хүрээнд хэвлэлийн багтай хамтран рийл бичлэг хийн, цахимаар иргэд олон нийтэд түгээж ажиллав.	2025.01.06 2025.06.06	90.0
	Арга хэмжээ 3.2. Нотариатын үйл ажиллагаанд хяналт тавьж, эрх олгуулах ажлыг зохион байгуулж, арга зүйгээр хангаж ажиллана.	Шийдвэрлэсэн хүсэлтийн хувь	-	90%	Сумдын нотариатчийн үүрэг гүйцэтгэгчдийн үйл ажиллагаанд зөвлөн туслах чиглэлээр “ӨВ.Нотариатчийн үүрэг гүйцэтгэгч нар” цахим бүлгийг ажиллуулж нотариатын үүрэг гүйцэтгэгчдээс асуусан асуултад тухай бүрд хариулт өгч, арга зүйн зөвлөмжөөр ханган ажиллаж байна.	2025.01.06 2025.06.04	90.0

	Дэд арга хэмжээ 3.2.1: Нотариатчийн үүрэг гүйцэтгэх эрх авах хүсэлтийг тухай бүрт холбогдох газарт уламжилж, эрх олгуулна.	Шийдвэрлэсэн хүсэлтийн тоо	Хүсэлт ирүүлсэн асуудлыг тухай бүрт шийдвэрлэж, арга зүйн зөвлөмж өгч ажилласан байна.	-	Тайлант хугацаанд Сант сумын Хууль, эрх зүйн мэргэжилтэнд шинээр нотариатчийн үүрэг гүйцэтгэчийн эрхийг олгуулах хүсэлтийг Хууль, зүй, дотоод хэргийн яаманд аймгийн Засаг даргын албан бичгээр уламжлан, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/02 дугаар тушаалаар эрхийг олгуулсан. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд нийт 16 суманд нотариатчийн үүрэг хавсран гүйцэтгэгч ажиллаж байна.	2025.01.06 2025.06.04	100.0
	Дэд арга хэмжээ 3.2.2: Нотариатчийн үүрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.	Арга зүйн зөвлөмжийн тоо	-	90%	Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран сумдын нотариатын үүрэг хавсран гүйцэтгэгч нарт Нотариатын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах арга зүйн сургалтыг 03 дугаар сарын 26-ны өдөр цахимаар зохион байгуулж, нийт 16 үүрэг гүйцэтгэгчийг сургалтад хамруулж ажиллав. Тайлант хугацаанд нотариатын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол гараагүй байна. Цаашид Нотариатийн үүрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагааг цахим нэвтрүүлэхээр төлөвлөн, туршлага судлан ажиллаж байна.	2025.01.06 2025.06.04	90.0
	Дэд арга хэмжээ 3.2.3: Нотариатчийн үүрэг гүйцэтгэгчийн үйлчилгээг цахимд нэвтрүүлэх ажлыг судлаж, холбогдох арга хэмжээг зохион байгуулна.	Эрх бүхий байгууллагуудад хүргүүлсэн хүсэлтийн тоо	-		Нотариатчийн үүрэг гүйцэтгэгчийн үйлчилгээг цахимд нэвтрүүлэх чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн яам, Нотариатчдын танхимаас арга зүйн зөвлөмж авахад Нотариатын цахим үйлчилгээнд ашиглах техник хэрэгслийг шийдвэрлэсний дараа, программын эрхийг Нотариатын танхимаас авар талаар судалсан бөгөөд аймгийн Засаг даргын орлогчид шийдвэрлэх талаар санал танилцуулан, 2025 оны 3-4 дүгээр улиралд зарим сумдын Нотариатчийн үүрэг гүйцэтгэгчийн үйлдлийг цахим системд шилжүүлэх талаарх үйл ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөж байна.	2025.01.06 2025.06.04	70.0
	Зорилт 4. “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулахад удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллана”						
4.	Арга хэмжээ 4.1. Орон нутагт Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулахад хяналт тавьж ажиллана.	Улсын байцаагчтай байгуулсан гэрээний хэрэгжилийн хувь	2-оос доошгүй	90%	Орон нутагт Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр улсын байцаагчийг гэрээгээр ажиллуулж байгаа бөгөөд улсын байцаагчийн үйл ажиллагаанд зөвлөн туслан, хяналт тавьж хамтран ажиллаж байна.	2025.01.06 2025.06.04	90.0

					Тайлант хугацаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Монополын эсрэг газрын ажлын хэсэг 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс 07-ны өдрүүдэд тус аймагт ажиллах үеэр үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан. Мөн Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авах ажлыг зохион байгуулах хүрээнд сумдын Засаг дарга нарт хэлтсийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 08-ний өдрийн “Хуулийн төсөлд санал авах тухай” 3-2/229 дүгээр албан бичгээр чиглэл хүргүүлэн, хуулийн төсөлд санал авах ажлыг аймгийн хэмжээнд цахимаар зохион байгуулан ажиллав.		
	Дэд арга хэмжээ 4.1.1: Монополын эсрэг газрын тус аймаг дахь улсын байцаагчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, арга зүйгээр хангаж ажиллана.	Үүрэг чиглэл өгсөн тоо	3 удаа	90%	Монополын эсрэг газрын орон нутаг дахь улсын байцаагчийн үйл ажиллагаанд тухай бүрд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллаж байна. Тухайлбал: Албаны үйл ажиллагаагаа хэвийн яюулахад шаардагдах тавилга хэрэгслийн зардалд 2.6 сая төгрөгийг аймгийн Засаг даргын 2025 оны “Дэмжлэг үзүүлэх тухай” А/295 дугаар захирамжийг батлуулж, шаардагдах зардлыг шийдвэрлүүлсэн. Мөн сар бүр холбогдох тогтоол шийдвэрийн биелэлтийг хянаж холбогдох хэлтэст хугацаанд хүлээлгэн өгч ажиллав.	2025.01.06 2025.06.04	90.0
	Дэд арга хэмжээ 4.1.1: Улсын байцаагчийг 2025 онд ажиллуулах шийдвэрийг боловсруулан батлуулна.	Шийдвэрийн хэрэгжилтээр	Аймгийн Засаг даргын 2024 оны Б/02 дүгээр захирамж	100%	Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн Б/03 дугаар захирамжаар Монополын эсрэг газрын орон нутаг дахь улсын байцаагчийг гэрээгээр түр ажиллуулах тухай шийдвэрийг батлуулж, 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл гэрээгээр түр ажиллуулахаар шийдвэрлүүлсэн бөгөөд улсын байцаагчийг орон нутгаас цалинжуулж, ажлын байр, шаардлагатай компьютер техник хэрэгсэл, бензин шатахуун зэрэг бусад зардлаар ханган ажиллаж байна	2025.01.27 2025.06.04	100.0
	Дэд арга хэмжээ 4.1.2: Монополын эсрэг газрын тус аймаг дахь улсын байцаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.	Гэрээний хэрэгжилтийн хувь	2024 онд хөдөлмөрийн гэрээ байгуулсан	-	Өрсөлдөөний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хангуулах зорилгоор Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн Б/03 дугаар захирамжийн хүрээнд Монополын эсрэг газрын орон нутаг дахь улсын байцаагч Гомбосүрэнгийн Амардэлгэртэй Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс 6 сарын	2025.01.08 2025.06.04	100.0

					хугацаатай хөдөлмөрийн гэрээг байгуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.		
--	--	--	--	--	--	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд							
1.1	Хуулийн байгууллагуудын ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг танилцуулахад хамтран ажиллах	-	-	Ёс зүйн дэд хороодтой хамтран ажилласан байх	Төрийн албаны зөвлөлөөс 01 сарын 06-ны өдөр төрийн албан хаагчдад зохион байгуулсан төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн сургалтыг зохион байгуулахад хамтран ажилласан. Мөн 01 сарын 07-ны өдөр хуулийн байгууллагуудын “Ёс зүйн дэд хороод”-ын үйл ажиллагаатай төрийн албаны зөвлөлийн ажлын хэсэг танилцан, мэргэжил арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагааг хамтран зохион байгуулан ажилласан.	2025.01-04 2025.01.07	100.0
1.2	Насанд хүрээгүй хүүхэд, өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Засаг даргын Албан даалгавар гаргах	Албан даалгавар гаргасан байх	-	Албан даалгавар гаргаж, сумд, холбогдох байгууллагуудад хүргүүлэх	Насанд хүрээгүй хүүхэд, өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Засаг даргын Албан даалгаврын төслийг боловсруулан, удирдлагуудад танилцуулж, саналыг тусган аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дүгээр “Албан даалгаврыг” гарган, холбогдох байгууллагуудад, сумдад хэлсийн даргын 01 дүгээр сарын 28-ны өдрийн 3-2/60 дугаар албан бичгээр хүргүүлж, Мөн олон нийтийн сүлжээгээр цахимаар иргэдэд албан даалгаврыг сурталчлан ажиллав.	2024.01.13 2025.01.28	100.0
1.3	Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран сургалт зохион байгуулах	Сургалтад хамрагдсан хүний тоо	-	Сургалтад сумын Засаг дарга нарыг оролцуулсан байх	Хэлтсийн даргын 2025 оны 01 сарын 14-ний өдрийн 3-2/20 дугаар албан бичгээр сумдын Засаг дарга нарт Нийтэд тустай ажил хийлгэх ажлын талаар танилцуулах, хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох сургалт, уулзалтад сумын Тамгын дарга нарыг оролцуулах чиглэл хүргүүлсний хүрээнд 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр аймгийн Шүүхийн	2025.01.14 2025.01.24	100.0

					шийдвэр гүйцэтгэх газартай хамтран сургалт, уулзалтыг зохион байгуулж, сумдын Засаг даргын Тамгын гарын нарыг оролцуулав.		
1.4	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомжийн хэрэглээ хангайн бүсийн хэлэлцүүлэг зохион байгуулах	Хэлэлцүүлэгт хамрагдсан хүний тоо	-	Хэлэлцүүлгийн зохион байгуулалтыг хариуцан, тэмдэглэл хөтлөж, хүлээлгэн өгсөн байх	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомжийн хэрэглээ хангайн бүсийн (Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймаг) сургалт, хэлэлцүүлгийг Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хорооны ажлын алба, Засгийн газрын хэрэг эхлэх газрын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэгтэй хамтран 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр аймгийн Гэр бүл хүний хөгжлийн төвд зохион байгуулж, хангайн бүсийн Ёс зүйн дэд хорооны нийт 100 төрийн алба хаагчийг оролцуулан ажиллав. Тус хэлэлцүүлгийн тэмдэглэлийг хөтлөн, баталгуужуулж, холбогдох албан хаагчид хүлээлгэн өгч ажиллав.	2025.05.12 2025.05.19	100.0

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1.1. Мэдлэг, чадвараа нэмэгдүүлэх цахим болон танхимын сургалтад хамрагдах	Суралцсан эсэх	2024 онд УА-ын сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан.	60%	2025 оны 03 дугаар сарын 15,16-ны өдрүүдэд аймгийн Политехнийкийн коллеж дээр зохион байгуулагдсан худалдан авах ажиллагаан АЗ сертификат олгох өдрийн танхимын сургалтад хамрагдаж, 19-ны өдөр хуулийн шалтгалт өгч, сертификат авсан. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 4 сарын 16-ны өдөр зохион байгуулсан бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг	2025.03.15 2025.05.15	

					дүгнэх цахим хэлэлцүүлэгт оролцсон. Төр, хувийн хэвшлийн төв, аймгийн ЗДТГ-ын ХБХОТХ-с 01 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулсан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн сургалтад хамрагдсан.		
2.	Арга хэмжээ 1.2. Хариуцсан ажлын чиглэлээр албан бичгийг монгол бичгээр төлөвлөж, монгол бичгийн чадвараа нэмэгдүүлэх	Монгол бичгээр төлөвлсөн албан бичгийн тоо	-	50%	Монгол бичгийн чадвараа нэмэгдүүлэх хүрээнд монгол бичгээр албан бичиг төлөвлөж сурахаар kimo.mngl.net цахим програмыг ашиглаж байна. Тайлант хугацаанд 2 албан бичгийг монгол бичгээр байгууллагад хүргүүлсэн байна.	2025.01.06 2025.06.04	50.0

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны
асуудал хариуцсан мэргэжилтэн
(Албан тушаал)

..... / 3.Нацагням /
(Нэр, гарын үсэг)

.....
(Огноо)